



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2023 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 14/09

Пионер толгой

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2020 оны 21/01 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах журам”-ын 2.2, 2.4 дахь заалтыг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Баянхонгор аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 11 дүгээр сарын 21 ны өдрийн 2022/ШЦТ/208 дугаар шийтгэх тогтоолоор иргэн Д.Очироос хураагдаж улсын орлого болгохоор тусгагдсан Солонгос улсад үйлдвэрлэгдсэн DOOSAN маркын SL-55-G20230 арлын тугаартай улбар шар өнгөтэй Тракторын худалдах доод үнийг 5400,000 (таван сая дөрвөн зуун мянга) төгрөгөөр, тогтоож нээлттэй дуудлагын худалдаагаар худалдсугай.

2. Дуудлага худалдаа явуулах ажлын хэсгийн Ахлагчаар Засаг даргын Тамгын газрын дарга Р.Гантулга

3. Гишүүд Ш.Нархүү БОХУБайцаагч

Б.Туулцэцэг Төсөв төрийн сангийн мэргэжилтэн

Б.Мөнхдалай Нийгмийн хөгжлийн ажилтан

Б.Баттулга Багийн засаг дарга нарыг томилсугай.

3. Нээлттэй дуудлагын худалдааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж орлогыг сумын Орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлэх;

3.2. Энэ тогтоолын биелэлтийг 2023 оны 08 дугаар сард багтаан Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд ирүүлэх.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Нарийн бичгийн дарга (С.Алтанцэцэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА Ч.ЭРДЭНЭ-ОЧИР



648801015